



“СҮЛД-АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК

*2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар
болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Улаанбаатар хот

2023 он



“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2023.03.24 № 23/22
танай _____-ны № _____

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Санал дүгнэлт

Бид “Фронтинер Лэнд Групп” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “Фронтинер Лэнд Групп” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ

тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДАЙ ХОЛБООТОЙ УДИРДЛАГЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД АУДИТОРЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал, /МНБ/ Ч.ГҮНДБАЯР




**"ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП" ХК-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

/төгрөг/

Д/Д	А. ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ	Үлдэгдэл	
		1-р сарын 01	12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,288,056,163.17	38,938,093.74
1.1.2	Дансны авлага	2,064,564,311.52	4,085,829,768.55
1.1.3	Татвар НДШ-н авлага	563,081.77	13,293,394.98
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,209,699,197.18	1,209,699,197.18
1.1.6	Бараа материал	102,978,542.00	99,585,928.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	158,875,000.00	4,718,250.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (Борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,824,736,295.64	5,452,064,632.82
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн Хөрөнгө	1,608,290,146.98	1,603,459,948.23
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул Үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	448,584,506.54	448,584,506.54
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,056,527,071.91	1,056,527,071.91
1.2.9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,113,401,725.43	3,108,571,526.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,938,138,021.07	8,560,636,159.50
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	2,299,104.00	1,277,280.00
2.1.1.3	Татварын өглөг	2,154,209.01	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	-	-
2.1.1.10	Бусад /Богино Хугацаат өр төлбөр/	-	-
2.1.1.11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,453,313.01	1,277,280.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,453,313.01	1,277,280.00
2.3	Эздийн өмч	13,750,000,000.00	13,750,000,000.00
2.3.1	Өмч: -төрийн	-	-
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	13,750,000,000.00	13,750,000,000.00
2.3.4	Халаасны хувьцаа	(4,497,462,000.00)	(4,497,462,000.00)
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	3,144,262,800.00	3,144,262,800.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(3,463,116,091.94)	(3,837,441,920.50)
2.3.9	Эздийн өмчийн дүн	8,933,684,708.06	8,559,358,879.50
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,938,138,021.07	8,560,636,159.50

Санхүүгийн тайлан баталгаажуулсан аудитор

Танилцсан нягтлан бодогч



**"ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП" ХК-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

/төгрөг/

Б.ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,666,973.63
2	Борлуулалтын өртөг	-
3	Нийт ашиг (алдагдал)	1,666,973.63
4	Түрээсийн орлого	-
5	Хүүний орлого	-
6	Бусад орлого	-
7	Борлуулалт, маркетингийн зардал	-
8	Ерөнхий ба удирдлагын зардал	406,964,846.63
9	Санхүүгийн зардал	-
10	Бусад зардал	-
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	30,972,044.44
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-
13	Бусад ашиг(алдагдал)	-
14	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(374,325,828.56)
15	Орлогын татварын зардал	-
16	Татварын дараах ашиг /алдагдал	(374,325,828.56)
В.ЭЗДИЙН ӨМЧИЙН ТАЙЛАН		
1	Эздийн өмчийн эхний үлдэгдэл	8,933,684,708.06
2	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(374,325,828.56)
3	Өмчид гарсан өөрчлөлт	-
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-
6	Эздийн өмчийн эцсийн үлдэгдэл	8,559,358,879.50
Г.МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,528,341.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	391,415,374.37
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(389,887,033.37)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
2.1	Мөнгөн орлогын дүн	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	1,890,203,080.50
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(1,890,203,080.50)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
3.1	Мөнгөн орлогын дүн	30,972,044.44
3.2	Мөнгөн зарлагын дүн	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	30,972,044.44
4	Валютын ханшын зөрүү	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,249,118,069.43)
6	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	2,288,056,163.17
7	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,938,093.74

Санхүүгийн тайлан баталгаажуулсан аудитор

Танилцсан нягтлан бодогч


Мүрээсүхэн
Дун